

1991 оны мал тооллого

I. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн байдал

I.1. Малчдын тоо, бүрэлдэхүүн. Хөдөө аж ахуйн улс, хоршооллын болон үйлдвэр аж ахуйн газар, байгууллага, пүүс, хоршооллын мал маллаж буй хүмүүс ардын аж ахуйтныг оруулахад 1991 оны жилийн эцсийн байдлаар нийт 115 мянган өрхийн 245 мянган малчид ажиллаж байна. Малчин өрхийн тоо өмнөх оныхоос 1.5 дахин, малчдын тоо 1.7 дахин буюу 97.5 мянгаар нэмэгдэв.

Нийт малчдын 56.5 хувь нь 16-35 насны залуучууд, 12.3 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

Улсын хэмжээгээр 8.0 мянган ардын аж ахуйтан өрх байгаагийн 54 хувь нь Хөвсгөл, Увс, Дорнод аймагт байна.

1990 онд нэг малчинд дунджаар нийгэм, амины 175 толгой мал ногдож байсан бол 1991 онд 104 толгой мал ногдох болов.

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

	1989	1990	1991
Малчин өрх (мян)	69.0	74.7	115.0
Малчдын тоо (мян)	135.4	147.5	245.0
Насны бүрэлдэхүүн (хувиар)	100.0	100.0	100.0
Үүнээс: 16-35 насны	51.0	55.7	56.5
36-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	45.0	40.3	31.2
Тэтгэврийн насны	4.0	4.0	12.3

I. 2. Малчдын соёл, ахуйн зарим үзүүлэлт. Цахилгаан гэрлээр хангагдсан малчин өрх 1990 онд 11.2 мянга байсан бол 1991 онд 12.3 мянга боллоо. Сэлэнгэ, Дорноговь, Төв аймагт малчин өрхийн 20.5-32.3 хувь нь цахилгаан гэрэлтэй байхад Өвөрхангай, Завхан, Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Увс, Ховд аймагт энэ үзүүлэлт дөнгөж 4.2-8.7 хувьтай байна.

1991 онд малчин өрхийн 10.5 хувь буюу 12.1 мянган өрх эсгий хийж гэр ахуйдаа ашиглажээ.

Малчин өрхийн 36 хувь буюу 41.4 мянган өрх гэрийн даавуу бүрээсгүй, 40.4 хувь буюу 46.4 мянга нь брезентэн бүрээсгүй байна. Өмнөх оныхтой харьцуулахад гэрийн даавуу болон брезентэн бүрээсний хангамж ихээхэн муудлаа. Ялангуяа Увс, Сүхбаатар, Архангай, Булган, Баянхонгор, Өмнөговь аймагт малчдын гэрийн 40.3-51.8 хувь нь даавуу болон брезентэн бүрээсгүй,

Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай аймагт малчин өрхийн 42.3-54.3 хувь нь брезентэн бүрээсгүй байна.

Малчин өрхийн 19.3 хувь буюу 22.2 мянга нь радио хүлээн авагчгүй байгаагийн дотор Увс аймагт гурван өрх тутмын нэг нь, Хөвсгөл, Ховд аймагт дөрвөн өрх тутмын нэг нь радио хүлээн авагчгүй байна. Улсын хэмжээгээр 4.2 мянган малчны өрх телевизортой байна.

I.3. Мал аж ахуйн мэргэжилтний хүрэлцээ хангамж. Мал аж ахуйн үйлдвэрлэлд 1347 бригад, хэсэг ажиллаж байна. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бригад, хэсгийн дарга 980, малын эмч 1599, мал зүйч 787, тоо бүртгэгч 652 ажиллаж байгаа нь 1990 оныхоос малын эмч 55-аар нэмэгдэж, мал зүйч, тоо бүртгэгч нарын тоо 169-260-аар буурлаа.

Одоо улсын дунджаар мал аж ахуйн бригад хэсэгт байгаа малын нэг эмчид 16.0 мянга, мал зүйчид 32.4 мянган мал ногдож буй нь 1990 оныхоос малын нэг эмчид ногдох мал 0.7 мянгаар буурч, мал зүйчид ногдох нь 5.4 мянгаар нэмэгджээ.

Мал аж ахуйн мэргэжилтний тоо,
хангамж (мян)

	1989	1991
Мал зүйч	1214	787
Малын эмч	1827	1599
Нэг мал зүйчид ногдох малын тоо (мян.тол)	20.3	32.4
Нэг малын эмчид ногдох малын тоо (мян.тол)	13.5	16.0

Гэрээ түрээсээр ажиллагч малчин өрх. 1991 онд 11.5 мянган малчин өрх аж ахуйтайгаа энгийн гэрээтэй ажиллаж байгаа нь 1990 оныхоос 3.4 дахин багасчээ. Мал түрээслэн ажиллаж буй малчин өрх 56.0 мянгад хүрч өмнөх оныхоос 6.8 дахин нэмэгдэв.

1991 онд нийт малчин өрхийн 10.0 хувь нь энгийн, 48.7 хувь нь түрээсийн гэрээтэй ажилласан байна. Баянхонгор, Баян-Өлгий, Сэлэнгэ, Өвөрхангай, Булган аймгийн нийт малчин өрхийн 65.4-89.6 хувь нь түрээсийн гэрээнд, Дундговь, Увс, Завхан аймгийн малчин өрхийн 17.7-18.8 хувь нь энгийн гэрээнд хамрагджээ. Улсын хэмжээгээр энгийн болон түрээсийн гэрээнд 8.6 сая мал хамрагдаж байна.

Хувьчлагдсан мал. 1991 онд 180.5 мянган өрх хувьчлалаар 4.5 сая мал авсны дотор 2.3 сая нь хээлтэгч мал байна. Нийгмийн өмчид хамрагдаж байсан нийт малын 25.8 хувь нь, хээлтэгч малын 26.0 хувь нь хувьчлалд хамрагджээ.

Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Ховд аймгийн нийгмийн малын 30.8-36.1 хувь нь хувьчлагдсан байна.

Нийгмийн аж ахуйн тэмээний 27.9 хувь буюу 125.5 мянга, адууны 25.6 хувь буюу 329.7 мянга, үхрийн 24.3 хувь буюу 337.4 мянга, хонины 25.3 хувь

буюу 2.9 сая, ямааны 26.7 хувь буюу 860.4 мянга нь хувьчлагджээ. Баянхонгор, Ховд аймагт нийгмийн ингэнийхээ гуравны нэгийг, Архангай аймагт гүүнийхээ 85.2 хувийг, Өмнөговь, Архангай аймагт үнээнийхээ тавны хоёрыг, Архангай, Өмнөговь аймагт эм хонь, ямааны 42-58 хувийг хувьчилжээ.

II. МАЛЫН ТОО

2.1. Нийт малын тоо. 1991 оны эцэст 25.5 сая мал тоологдсон нь 1990 оныхоос 329 мянгаар буурсны дотор ямаа 123.8 мянгаар нэмэгдэж, хонь 362 мянгаар, тэмээ 61.5, үхэр 26.7, адуу 2.7 мянгаар цөөрөв.

Малын тоо (мян.тол)

	1990	1991	1991/1990	
			%	Зөрүү
Бодоор *	9071.5	8905.0	98.2	-166.4
Толгойн тоо	25856.9	25527.9	98.7	-329.0
Тэмээ	537.5	476.0	88.6	-61.5
Адуу	2262.0	2259.3	99.9	-2.7
Үхэр	2848.7	2822.0	99.1	-26.7
Хонь	15083.0	14721.0	97.6	-362.0
Ямаа	5125.7	5249.6	102.4	123.8

* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцов.

Нийт 8 аймаг, 3 хот малынхаа тоог 1990 оныхоос өсгөв. Баянхонгор, Дундговь, Булган, Сүхбаатар аймаг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотын малын тоо өнгөрсөн оныхоос бодод шилжүүлснээр 4.8-21.4, толгойн дүнгээр 19.5-75.4 мянгаар нэмэгдсэн байна.

Дундговь, Булган, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймаг тэмээнээс бусад төрөл дээр малаа өсгөв. Сумдаас Баянхонгорын Баянбулаг, Гурванбулаг, Дундговийн Говь-Угтаал, Төвийн Аргалант, Баянцогт зэрэг 9 аймгийн 18 сум малаа төрөл бүр дээр нь өсгөжээ.

Малын тоо 10 аймагт урьд оныхоос буурсны дотор Баян-Өлгий, Хөвсгөл, Хэнтий, Увс аймаг малаа 81.4-158.5 мянгаар хорогдуулжээ. Улсын хэмжээний 305 сумдын дотор малынхаа тоог урьд оныхоос 22.6-39.9 хувь буюу 10.8-51.3 мянгаар хорогдуулсан Завханы Баянтэс, Увсын Давст, Төв аймгийн Архуст, Хэнтийн Өлзийт, Баян-Өлгийн Баяннуур сумд сүүлийн байранд орж байна.

Тэмээний тоо толгой жил дараалан хорогдсоор байна. 1991 онд улсын хэмжээгээр анх удаагаа 476 мянган тэмээ тоологдсон нь урьд жилийнхээс 62 мянгаар буурав. Энэ бууралт нь манай орны хамгийн олон тэмээтэй Өмнөговийн тэмээний тооны 53 хувьтай тэнцэх тоо юм.

Тэмээний тоо толгойг хэрхэн буурч байгааг дараах хүснэгтээс харж болно.

	Дундаж тоо (мая.тол)	Өмнөх онуудаас буурсан хэмжээ (маян.тол)
1951 – 1960 онд	870.0	-
1961 – 1970 онд	755.0	115.0
1971 – 1980 онд	611.0	144.0
1981 – 1990 онд	562.0	49.0

1954 онд манай улс 895 мянган тэмээтэй байсан бол жилээс жилд цөөрсөөр одоо тоо толгой нь бараг 2 дахин хорогдоод байна. Гучин жилийн өмнөхтэй харьцуулахад зөвхөн Увс, Говь-Алтай аймаг тэр үед байсан тэмээний тооны 90 хувьтай тэнцэх тэмээтэй үлджээ. Гэтэл Архангай, Төв аймгийн тэмээний гуравны хоёр, Завхан, Өвөрхангай, Хэнтий аймгийн тэн хагасаас илүү нь үгүй болжээ.

Тэмээний зүй бус хорогдол буурч, 100 эхээс бойжуулсан ботго нэмэгдэж ирсэн билээ. Ингэхээр тэмээг хүнсэнд хэрэглэх болсон нь түүний тоо буурсан үндсэн шалтгаан юм. 1991 онд улсын хэмжээгээр 53 мянган ботго бойжуулсан байхад, 21 мянган тэмээ зүй бусаар хорогдож, 94 мянган тэмээг хүнсэнд хэрэглэжээ. Тэмээ эмнэгшиж, ачлага уналганд бага хэрэгддэг болохын хэрээр хүнсний хэрэгцээг илүү хангах болсон байна.

Улсад нийт малаар болон хонины тоогоор Завхан, адуугаар Төв, үхрээр Хөвсгөл, ямаагаар Баянхонгор, тэмээгээр Өмнөговь аймаг тэргүүн байранд хэвээр байна. Хамгийн олон малтай сумын тоонд Дундговь аймгийн Эрдэнэдалай сум нийт малын тоогоор (245.4 мян) болон хонь (140 мян), адуугаар (28.5 мян), Өмнөговийн Ханбогд сум тэмээгээр (17.7 мян), Архангайн Хангай сум үхрээр (32.5 мян), Өвөрхангайн Богд сум ямаагаар (79.7 мян) тус тус орж байна.

Хувийн (амины) малын тоо. 1991 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 288.9 мянган өрх байгаа нь өмнөх оныхоос 26.6 мянгаар нэмэгдсэн байна.

1991 онд нийгмийн малын 25.8 хувийг хувьчилснаар амины малын тоо 14 саяд хүрч нийт малын 54.9 хувийг эзлэх болов. Энэ үзүүлэлт 1990 онд 31.9 хувь байв. Амины малын тоо ноднингийнхоос 1.7 дахин буюу 5.8 саяар нэмэгдэж, нийгмийн мал 34.6 хувь буюу 6.1 саяар буурсан байна. Үхэр, адуу, ямааны 61, 3-67.2, хонины 49.0, тэмээний 39.1, бодод шилжүүлсэн малын 59.2 хувь нь амины аж ахуйд ногдох болжээ. Бүх аймаг, хотод амины малын тоо урьд оныхоос 1.2-3.1 дахин өссөний дотор Дорноговь, Сэлэнгэ, Баян-Өлгий аймагт 111.4-191.2 мянга, Сүхбаатар, Булган аймагт 245.9-297.4 мянга, бусад аймагт 304.9-459.0 мянгаар нэмэгдэв.

Амины малын нийт өсөлтийн 78.8 хувийг хувьчлалаар нийгмийн малаас аминд шилжиж ирсэн өсөлтөөр, үлдэх хэсгийг сүргийн нөхөн үйлдвэрлэлийн өсөлтөөр хангасан байна.

Амины малын 72.6 хувь нь нэгдлийн гишүүдэд, 21.4 хувь нь ажилчин, албан хаагчдад, 6 хувь нь ардын аж ахуйтанд ногдож байна.

Аминд байгаа малын бүтцийг авч үзвэл хонь 51.5 хувь, ямаа 23, үхэр 13.5, адуу 10.7, тэмээ 1.3 хувийг эзлэж байна.

Нэгдлийн гишүүдийн 142.8 мянган өрхөд 10.1 сая амины мал тоологдсон нь урьд оныхоос малын тоо 3.7 саяар, өрхийн тоо 2.7 мянгаар нэмэгдэв. Нэгдлийн гишүүн малтай өрхөд нэгдлийн гишүүн малчдаас гадна нэгдлийн газар тариалан, туслах үйлдвэрийн малтай хүмүүс, тэтгэвэрт гарсан сум, аймаг, хотын төвд суудаг нэгдлийн гишүүн хүмүүс хамрагдаж байна. Улсын хэмжээгээр нэгдлийн гишүүн нэг өрхөд дунджаар 71 толгой мал ногдож байгаа нь өмнөх оныхоос 25 толгойгоор нэмэгдэв. Булган, Хөвсгөл, Архангай аймагт нэг өрхөд дунджаар 53-58 толгой мал ногдож байхад Дорноговь, Дундговь аймагт 105-111 толгой мал ногдож байна.

Нэгдлийн гишүүд

(тоо-мянгаар)

	Өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо	
	1990	1991	1990	1991	1990	1991
10 хүртэл малтай	16.1	7.2	11.6	5.1	101.2	51.5
11-30 малтай	40.8	24.6	29.4	17.2	845.5	556.7
31-50 малтай	32.1	29.6	23.1	20.7	1275.7	1227.6
51-100 малтай	38.5	49.0	27.8	34.3	2705.6	3483.2
101-200 малтай	10.7	27.7	7.7	19.4	1346.9	3677.3
201-с дээш малтай	0.5	4.7	0.4	3.3	120.7	1146.5
ДҮН	138.7	142.8	100.0	100.0	6395.7	10142.8

Ажилчин, албан хаагчдын 138.2 мян. өрхөд 2990.3 мянган мал тоологдсон нь урьд оныхоос малын тоо 1.1 сая, өрхийн тоо 16 мянгаар нэмэгдлээ. Ажилчин, албан хаагчдын нэг өрхөд дунджаар 22 толгой мал ногдож байгаа нь урьд оныхоос 7-гоор нэмэгдэв.

Малтай ажилчин, албан хаагчид

(тоо-мянгаар)

	Өрхийн тоо		Дүнд эзлэх хувь		Малын тоо	
	1990	1991	1990	1991	1990	1991
10 хүртэл малтай	60.3	57.6	49.3	41.7	322.4	349.6
11-30 малтай	47.3	46.2	38.7	33.4	853.8	820.9
31-50 малтай	10.5	19.9	8.6	14.4	394.0	758.9
51-100 малтай	4.1	12.5	3.4	9.0	276.7	795.8
101-200 малтай	-	1.9	-	1.4	-	238.8
201-с дээш малтай	-	0.1	-	0.1	-	26.4
ДҮН	122.2	138.2	100.0	100.0	1846.8	2990.3

Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот болон аймгийн төвийн малтай ажилчин, албан хаагчдын нэг өрхөд 1990 онд 9.3 толгой мал байснаа 1991 онд 11.3 толгой, сум, хороо, орон нутгын хот суурингийн ажилчин, албан хаагч нэг өрхөд ногдох мал 18.3 толгой байснаа 27 толгой болж өсөв.

Ардын аж ахуйтан өрх Баян-Өлгий, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойр хотоос бусад бүх аймагт бий болж улсын дүнгээр 8.0 мянга болоод байна. Ардын аж ахуйтан өрх Ховдод 7, Дундговьд 10 байгаа бол Хөвсгөл, Увс, Дорнодод 1.5-2.0 мянгад хүрчээ.

Ардын аж ахуйтан

(тоо-мянгаар)

	Өрхийн тоо		Малын тоо
	1991	Дүнд эзлэх хувь	
10 хүртэл малтай	0.2	2.7	1.1
11- 30 малтай	0.9	10.6	18.6
31—50 малтай	1.4	17.1	57.5
51-100 малтай	2.4	30.2	188.2
101-200 малтай	2.2	27.9	316.9
201-ээс дээш малтай	0.9	11.5	248.8
ДҮН	8.0	100.0	831.1

Хээлтэгч мал. 1991 оны эцэст 11640.4 мянган хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 403 мянгаар буурчээ. Гүү, эм ямаанаас бусад төрлийн хээлтэгч малын тоо урьд оныхоос буурсан байна.

Хээлтэгч малын тоо (мян.тол)

	1990	1991	1991\1990	
			хувь	зөрүү
Ингэ	140.9	127.3	90.3	-13.6
Гүү	563.5	575.6	102.1	12.1
Үнээ	1127.2	1064.0	94.4	-63.2
Эм хонь	7786.1	7407.2	95.1	-378.9
Эм ямаа	2425.7	2466.3	101.7	40.6
ДҮН	12043.4	11640.4	96.7	-403.0

Баянхонгор, Булган, Архангай, Дундговьос бусад аймагт хээлтэгч малын тоо урьд оныхоос буурсан байна.

Бүх хээлтэгч малын 52.1 хувь нь нийгмийн, 47.9 хувь нь амины аж ахуйд байгаагийн дотор ингэний 33.8, гүүний 63.5, үнээний 59.6, эм хонины 42.3, эм ямааны 56.7 хувь амины аж ахуйд байна.

Нийгмийн хээлтэгч мал бүх аймагт буурч, улсын дүнгээр 2652.7 мянгаар цөөрөв.

Амины аж ахуйн хээлтэгч бүх мал аймаг, хотод өсч, улсын дүнгээр 2249.7 мянгаар нэмэгдсэн нь мал хувьчлалын үр дүнгээр (хувьчлагдсан хээлтэгч 2265.4 мянга) хангагджээ.

1991 онд 2212.8 мян.хээлтэгч шинээр нас дэвшиж нэмэгдсэн нь нийт хээлтэгчийн 19 хувь болж байна.

1991 онд 406.2 мян.хээлтүүлэгч мал тоологдсон нь урьд оныхоос 44.4 мянгаар буурчээ. Одоо нэг хээлтүүлэгчид улсын дунджаар 32 ингэ, 37-38 эм хонь, ямаа ногдож байгаа нь үржлийн нормоос ингэ 7, эм хонь, ямаа 7-8 толгойгоор их байна. Буур, хуц, ухна дутагдалтай байгаа нь өнгөрсөн онд мэдэгдэж байсан атал 1991 онд дөнгөж 14 буур, 3580 хуц, 1390 ухна шинээр нэмж тавьсан нь хангалтгүй болжээ.

Төл бойжилт. 1991 онд гарсан төлийн 93.8 хувь буюу 9.6 сая төл бойжуулав. Бойжсон нийт төлөөс 405.8 мянгыг улс, орон нутгийн бэлтгэлд, 628.9 мянгыг аж ахуйн дотоод хэрэгцээнд, 32.1 мянгыг каракуль арьсанд

нядалжээ. Улс орон нутгийн бэлтгэлд хэрэглэсэн төлийн тоо 1990 оныхоос 100.4 мянгаар буурав.

Төл бойжилт (мян.тол)

	Бүгд	Ү Ү Н Э Э С					Зөрүү
		ботго	Унага	тугал	хурга	ишиг	
Гарсан	10252.0	56.2	355.1	785.1	6938.8	2116.8	173.2
Бойжсон	9611.8	52.9	343.8	762.5	6468.9	1983.7	92.7
Хорогдсон	640.2	3.3	11.3	22.6	469.6	133.1	80.5
Бойжилтын хувь	93.8	94.1	96.8	97.1	93.2	93.7	-

1992 онд 100 эхээс бойжуулсан төл өмнөх таван жилийн дунджаас 1-ээр, 1991 оныхоос 3-аар бага байна.

100 эхээс бойжуулсан төл

	1986-1990 оны дундаж	1990	1991	Үүнээс :	
				амь	нийгэм
Ботго	40	38	38	51	35
Унага	62	61	61	76	48
Тугал	69	70	68	85	53
Хурга	86	88	83	96	80
Ишиг	80	82	82	87	79
Бүгд	81	83	80	90	76

100 хээлтэгчээс Сүхбаатар, Дундговь, Баянхонгор аймаг 86-88 төл бойжуулсан байхад, Хэнтий, Төв, Дорнод аймаг 65-71 төл бойжуулжээ.

Амины 100 эх малаас бойжуулсан төл нийгмийнхээс 14-өөр, үүний дотор ботго 16, хурга 16, унага 28, тугал 32, ишиг 8-аар илүү байна.

Том малын зүй бус хорогдол. 1991 оны эхний малын 3.8 хувь буюу 978.2 мянган том мал зүй бусаар хорогдсон нь 1990 оныхоос 305 мянга, 1986-1990 оны дунджаас 226.3 мянгаар нэмэгдсэн байна.

Том малын зүй бус хорогдол
(мян.тол)

	1986-1990 оны дундаж	1990	1991
Тэмээ	25.8	31.2	20.8
Адуу	64.3	70.4	72.7
Үхэр	79.5	73.1	104.6
Хонь	438.7	369.4	624.1
Ямаа	143.6	129.1	156.0
Бүгд	751.9	673.2	978.2

Оны эхний малд зүй бус
хорогдолын эзлэх хувь

	1986- 1990оны дундаж	1990	1991
Тэмээ	4.7	5.6	3.9
Адуу	3.1	3.2	3.2
Үхэр	3.1	2.7	3.7
Хонь	3.3	2.6	4.1
Ямаа	3.2	2.6	3.0
Бүгд	3.3	2.7	3.8

Хэнтий, Төв, Дорнод, Баян-Өлгий аймагт оны эхний малын 6.2-8.6 хувь буюу нийтдээ 72.6-128.9 мянган том мал зүй бусаар хорогдсон нь улсын хэмжээний нийт хорогдлын тавны хоёрыг эзлэж байна.

Том малын зүй бус хорогдолын 39.4 хувь буюу 385.2 мянга нь өвчнөөр, 24.4 хувь буюу 238.4 мянга нь гэнэтийн аюулаар хорогдов. Хорогдсон нийт малын 86.2 хувь нь нийгмийн мал байна.

Малын хээл хаялт, сувайралт. 1991 оны эхний хээлтэгч малын 12.9 хувь буюу 1552.3 мянга нь хээл хаясан, сувайрсан шалтгаанаар төл өгөөгүй нь 1990 оныхоос 31.2 хувь буюу 356.3 мянгаар их байна. Хэнтий, Архангай, Дорнод, Хөвсгөл, Төв, Булган аймагт малын хээл хаялт, сувайралт харьцангуй их гарч оны эхний эх малын 16.4-20.8 хувьд хүрчээ.

Дөрвөн төрлийн хорогдол. 1991 онд төл, том малын хорогдол, хээл хаясан сувайрсан мал 3170.7 мянгад хүрсэн нь 1990 оныхоос 30.5 хувь буюу 741.8 мянгаар ихэссэн байна. Дөрвөн төрлийн хорогдол Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Говь-Алтай, Баянхонгор аймагт 1990 оныхоос 1.2-74.8 мянгаар буурч бусад бүх аймаг, хотод нэмэгдсэний дотор Хэнтий, Хөвсгөл, Төв, Баян-Өлгий аймагт 106.6-165.7 мянгаар ихсэв.

Малын хэрэглээний зарлага. Малын нийт зарлага (төл, том малын зүй бус хорогдол ороогүй) 8930.4 мянга, үүнээс том малын хэрэглээний зарлага оны эхний малын 30.4 хувь буюу 7863.6 мянгад хүрсний дотор улс, орон нутгийн бэлтгэлд 14.8 хувь буюу 3824.2 мянга, аж ахуйн дотоод хэрэгцээнд 15.6 хувь буюу 4039.4 мянган мал зарцуулжээ. Аж ахуйн дотоодод, хүнсэнд хэрэглэсэн малын тоо өмнөх жилийнхээс 1.5 дахин нэмэгдсэн байна.

Том малын хэрэглээний зарлага. (мян.тол)

	1986-1990 оны дундаж	1991	1991\1989-1990	
			хувь	зөрүү
Хэрэглээний нийт зарлага	7559.8	8930.4	118.1	1370.6
Үүнээс : Том малын	6736.4	7863.6	116.7	1127.2
-Улсын бэлтгэлд	3445.6	3097.1	89.9	-348.5
-Орон нутгын бэлтгэлд	664.7	727.1	109.4	62.4
-Аж хауйн дотоод болон бусад	2626.1	4039.4	153.8	1412.7

Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Хэнтий аймагт оны эхний малынхаа 11.7 – 12.4 хувийг аж ахуйн дотоод хэрэгцээнд зарцуулсан байхад Баян-Өлгий, Ховд, Баянхонгор, Увс аймаг 18.3 – 23.6 хувийг зарцуулжээ.

Малын нийт хэрэглээний зарлага. (мян.тол)

	1986-1990 оны дундаж	1991
Бүгд	7559.8	8930.5
Тэмээ	38.9	93.6
Адуу	201.7	273.8
Үхэр	544.3	684.6
Хонь	5311.3	6174.6
Ямаа	1463.6	1703.9

Оны эхний малд эзлэх хувь

	1986-1990 оны дундаж	1991
Бүгд	31.8	34.5
Тэмээ	7.1	17.4
Адуу	9.5	12.1
Үхэр	20.8	24.0
Хонь	38.4	40.9
Ямаа	31.3	33.2

Сүргийн бүтэц. Нийт сүргийн 38.2 хувь нь төл, өсвөр насны, 45.6 хувь нь хээлтэгч, 14.6 хувь нь ажлын болон бэлтгэлийн насны эр, 1.6 хувь нь хээлтүүлэгч мал байна.

Сүргийн бүтэц (хувиар)

	Төл өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бүгд	Нийт малын
Тэмээ	34.3	38.1	26.7	0.8	100.0	1.9
Адуу	36.3	34.8	25.5	3.4	100.0	8.8
Үхэр	49.5	10.6	37.7	2.2	100.0	11.0
Хонь	37.1	11.2	50.3	1.4	100.0	57.7
Ямаа	36.1	15.6	47.0	1.2	100.0	20.6
ДҮН	38.2	14.6	45.6	1.6	100.0	100.0

Нийт сүрэгт хээлтэгч малын эзлэх хувийн жин 45.6 болж, урьд оныхоос 1.0 пунктээр буурсны дотор үнээ 1.9, эм хонь, 1.3, эм ямаа 0.3-аар буурч, ингэ, гүүний хувийн жин 0.5- 0.6 пунктээр нэмэгдэв. Амины болон нийгмийн аж ахуйн сүргийн бүтэц нэлээд ялгаатай байна.

Нийгэм, амны малын сүргийн бүтэц (хувиар)

		Төл өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	Хээлтэгч	Хээлтүүлэгч	Бүгд	Нийт малын
Тэмээ	Амь	37.8	38.5	23.1	0.6	100.0	1.3
	Нийгэм	32.1	37.8	29.1	1.0	100.0	2.5
Адуу	Амь	37.4	34.4	24.5	3.7	100.0	10.7
	Нийгэм	34.3	35.6	27.4	2.7	100.0	6.7
Үхэр	Амь	52.8	12.2	33.4	1.7	100.0	13.5
	Нийгэм	42.8	7.4	46.5	3.3	100.0	8.0
Хонь	Амь	41.0	15.2	43.4	0.3	100.0	51.5
	Нийгэм	33.3	7.4	56.9	2.3	100.0	65.2
Ямаа	Амь	39.1	17.0	43.5	0.4	100.0	23.0
	Нийгэм	31.5	13.5	52.5	2.5	100.0	17.6
Бүгд	Амь	41.7	17.6	39.8	0.9	100.0	100.0
	Нийгэм	33.8	11.1	52.7	2.4	100.0	100.0

1991 оны эцэст бэлтгэлийн насны 2773.3 мянган эр мал тоологдсон нь өмнөх оныхоос 411.7 мянгаар нэмэгджээ. Бэлтгэлийн насны эр хонь 366.6 мянга, эр үхэр 56.2 мянгаар нэмэгдэж, ямаа 11.1 мянгаар буурсан байна.

Нийгмийн аж ахуйд бэлтгэлийн насны эр хонь, үхэр тус бүр 7.4 хувийг эзлэж байхад амины аж ахуйд хонины 15.2, үхрийн 12.2 хувь нь бэлтгэлийн насных байна.

Бараг бүх аймаг, хотод амины аж ахуйн бог малын 10-20 бэлтгэлийн насны эр мал эзлэж байна.

Ажлын мал. 1991 онд ажил, эдэлгээний 133.4 мян.ат, 608.3 мян.морь, 41.7 мян.шар байгаа нь өмнөх оныхоос ат 3.4 мянга, морь 12.4 мянга, шар 9.6 мянгаар нэмэгджээ. Улсын хэмжээгээр атны 73.6 хувь, морины 77.3, шарны 13.9 хувийг ердийн хөсөгт ашиглаж байна.

II.2. Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал. 1991 оны эцэст цэвэр үүлдрийн 453.7 мянга, эрлийз 938.2 мянга, нутгийн шилдэг омгийн 899.6 мянган мал тоологдсон нь 1990 оныхоос цэвэр үүлдрийн мал 52.3 мянга, нутгийн шилдэг омгийн мал 341.3 мянга, эрлийз мал 407.1 мянгаар цөөрсөн байна.

\ хүснэгт 44-46 \

Цэвэр үүлдрийн үхрийн тоо Төв, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймаг, Улаанбаатар хотын аж ахуйнуудад 1.1-2.3 мянга, хонь Булган аймаг, Чойр хот, Төв, Хэнтий, Баянхонгор аймаг, Дархан хотод 2.9-13.1 мянга, ямаа Өмнөговь, Төв, Баянхонгор, Дорнод аймагт 1.5-10.0 мянгаар буурчээ.

1991 онд тоологдсон нийт үхрийн 7.4 хувь, хонины 6.2 хувь, ямааны 5.2 хувь нь цэвэр, эрлийз мал эзлэж байна. Нийт цэвэр эрлийз үхрийн 47.3, хонины 43.3, ямааны 7.5 хувь нь сангийн аж ахуйд байна.

1991 оны эцэст цэвэр үүлдрийн болон эрлийз 755.6 мянган хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оныхоос 203 мянгаар цөөрчээ. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын сүрэгт үнээ 47.8, эм ямаа 53.4, эм хонь 56.1 хувийг эзлэж байна.

Цэвэр, эрлийз болон нутгийн шилдэг омогын малын тооллогыг үнэн зөв явуулах ажлыг удирдан зохион байгуулахад хариуцлагагүй хандсанаас тодорхой үүлдэр, омгын малыг тооллогын данс бүртгэлд ялгаж тусгалгүй орхигдуулах явдал аймаг, орон нутагт нилээд гарсан байна. Тухайлбал Дундговь аймагт өнгөрсөн онд тоологдсон 31.7 мянган эрлийз хониноос нэг нь ч энэ жилийн цэвэр, эрлийз малын тооллогонд тусгагдсангүй.

IV. Тэжээвэр амьтад.

1991 оны эцэст 83.3 мянган гахай, 223.3 мянган шувуу, туулай 2.0, үнэг 1.2, булга 7.5 мянга тоологдов. 1990 оныхоос гахайн тоо 51.4 мянга, шувууны тоо 102.9 мянга, туулай 5.1 мянгаар буурсан байна.

Зөвхөн амины аж ахуйн салбарт шувуу өсч, бусад салбарт гахай, шувууны тоо их хэмжээтэй цөөрчээ. Үндсэн мэргийн тоо 26.6 хувь, өндөглөгчийн тоо 18.6 хувиар хорогдов.

Бүх аймаг, хотод гахайн тоо, Дорнод, Дундговь аймаг, Эрдэнэт хотоос бусад аймаг, хотод шувууны тоо хорогдсон байна. Улаанбаатар хотын гахайн заводын 6 мянга гаруй гахайн ихэнх нь өнгөрсөн онд үхэж хорогджээ.

1991 онд 62.7 мянган торой, 341.7 мянган дэгдээхэй бойжуулсан нь өмнөх оныхоос торой 38.1 мянга, дэгдээхэй 9.3 мянгаар буурсан байна.

Улсын төвлөрсөн болон аж ахуйн дотоод хэрэгцээнд 62.5 мянган гахай, 189.9 мянган шувуу хэрэглэсэн нь 1990 оныхоос гахай 47.5 мянгаар багасч, шувуу 97.3 мянгаар нэмэгдэв.

Сүүлийн жилүүдэд гахай, шувуутай өрх, аж ахуйн тоо цөөрөх хандлага ажиглагдах боллоо.

Үүнийг зөвхөн сүүлийн 2 жилээр зэрэгцүүлж үзүүлбэл :

	Гахайтай		Шувуутай	
	1990	1991	1990	1991
ХААН, НДҮ, НДХ	173	82	69	13
САА, ТАА	53	31	23	8
Албан газар	619	369	58	35
Айл өрх	15665	12053	1271	1329

* * * * *

1991 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогыг Засгийн газрын тогтоол, Улсын статистикийн газраас боловсруулсан маягт, зааврын дагуу, хугацаанд нь аймаг, орон нутагт зохион байгуулж явуулав.

Малыг оршиж байгаа нутаг дэвсгэрийн байгууллагын дансанд тусгалгүй орхих, тооллогоос нууж дарагдуулах зөрчил зарим газарт гарлаа. Өвөрхангай аймагт мал тооллогын бэлтгэл, зохион байгууллалт муу хангагдснаас урьдчилсан дүн гаргахад малынхаа тоог бүрэн хамруулан өгч чадаагүй байна. Тус аймгийн

Зүүнбаян-Улаан суманд улсын бэлтгэлд нядлана гээд нядлагдаагүй үлдсэн 700 малыг тооллогод хамруулалгүй орхисон, Сант суманд тоологдсон 186 малыг данс бүртгэлд оруулаагүй, 379 малыг Сант сум, Арвайхээр хотын хорооны дансанд давхардуулан оруулсан зэрэг мал тооллогын зааврыг ноцтой зөрчсөн дутагдал шалгалтаар илрэв.

Архангай аймгийн хашаат, Өндөр-Улаан сумын нутагт тоологдсон Улсыг аюулгүй байдлыг хангах ерөнхий газар, Телефон радио ашиглалтын хороо, Монгол такси компани зэрэг байгууллагын 1605 мал тухайн сумдын дансанд оролгүй орхигдсоныг нөхөн оруулав.

Чойр хотын Баянтал хорооны И.Баатар нарын долоон өрх айл 417 малыг тооллогоос нуун дарагдуулж байсан нь илэрч арга хэмжээ авагдсан байна.

Малын үүлдэр угсаа, анги чанарын бүртгэлийг сайжруулж, цэвэр, эрлийз малын тооллогод бүрэн хамруулах талаар Хөдөө аж ахуйн яам, аймаг, хотын АХ-ын гүйцэтгэх захиргаад зориуд анхааралдаа авч ажиллах шаардлагатай байна.

Тэмээн сүргийн тоо толгойн бууралтыг зогсоох талаар төр, засгийн тодорхой бодлого чухал болсон байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ГАЗРЫН ДАРГА.....Б.ЦЭНД-АЮУШ

1992 – 03 - 20